

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2021 оны 03 дугаар сарын 19-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: “CAT ACERT C15 хөдөлгүүр, их засварын ажилд шаардлагатай сэлбэг, материал” нийлүүлэх (2 багц)

Тендер шалгаруулалтын дугаар: МРЦМ/202112106

“Монголросцветмет” ТӨҮГ эрх бүхий тендерт оролцогчдоос **“CAT ACERT хөдөлгүүр, их засварын ажилд шаардлагатай сэлбэг, материал”** нийлүүлэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь **50,000.00 /тавин мянган/** төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: **2019, 2020 онд гүйцэтгэсэн борлуулалтын хэмжээ тендерийн үнийн саналын мөнгөн дүнгийн 50%-аас багагүй байна.**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **Тендерт ирүүлсэн үнийн саналын мөнгөн дүнгийн 100%-аас багагүй байна.**

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **2019, 2020 оны жилийн санхүүгийн тайлан дүгнэлтийн хамт, нотариатаар баталгаажуулсан хуулбар хувь ирүүлнэ.**

Тендерийн хамт:

Багц 1 – **4 800 000,00 /дөрвөн сая найман зуун мянга/**

төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 14:00 цагаас өмнө www.tender.gov.mn хаягаар ирүүлэх ба мөн өдрийн 14:05 цагт цахим системээр нээнэ.**

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: **Зөвшөөрнө.**

Дотоодын давуу эрх тооцох эсэх. **Тооцохгүй.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, БЗД 22-р хороо, Энхтайваны өргөн чөлөө – 98, 305 тоот өрөө, утас: 450060 + 243

“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ